**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 27 өдөр Дугаар 68 Улаанбаатар хот

Хурлын хороодыг хуралдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3, 52.1.4 дэх заалт, Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолын хавсралтын 5.1.2 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн 2023 оны ээлжит 09 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус тавдугаар хуралдааны тов зарлагдсантай холбогдуулан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, хянан шалгах, санал дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий хурлын хороодыг хуралдуулсугай.

2.Хурлын хороодыг хуралдуулах удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3.Хурлын хороод ажиллахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба (даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Туяа)-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА Б.МӨНХБАТ

1159209169

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2023 оны 10 дугаар сарын 27-ны
өдрийн 68 дугаар захирамжийн хавсралт

УДИРДАМЖ

Хурлын хороодыг хуралдуулах тухай

Нэг. Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хороод харьяалах асуудлын хүрээнд хуралдаж, санал дүгнэлт боловсруулна.

Хоёр. Хурлын Ажлын алба, Засаг даргын Тамгын газар, холбогдох хэлтэс албад Хурлын хороог шаардлагатай мэдээ мэдээлэл, тооцоо судалгаа, ажиллах нөхцөлөөр хангана.

Гурав. Хурлын хороо ажиллахад шаардагдах зардлын төсвийг Хурлын төсвийн зардлаас санхүүжүүлнэ.

Дөрөв. Хорооны ажиллах хуваарь, хэлэлцэх асуудал:

| Д/д | Хурлын хороод | Хэлэлцэх асуудал | Хугацаа | Хариуцах хэлтэс, алба |
|---|---|---|---|---|
| 1. | Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо | Дүүргийн 2023 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Өргөтгөсөн хэлбэрээр) | X/31-ний өдрийн $09^{00}$ цагт Хурлын танхимд | Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| 2. | Эрх зүй, нутгийн удирдлагын хөгжлийн хороо | Санал уламжлах тухай (Өргөтгөсөн хэлбэрээр) | X/31-ний өдрийн $12^{00}$ цагт Хурлын танхимд | -Төлөөлөгч, Монгол Ардын Намын бүлгийн дарга Д.Ядамжав,<br>-Дүүргийн Газар зохион байгуулалтын алба,<br>-Улсын бүртгэлийн хэлтэс |

ХУРЛЫН АЖЛЫН АЛБА